



**МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНКНЫ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2023 оны 11 сарын 21 өдөр

Дугаар А-141

Улаанбаатар хот

Бодлого батлах тухай

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг, 21.5.1 дэх заалт, Монгол Улсын Хөгжлийн банкны дүрмийн 9.2 дахь хэсэг, Гүйцэтгэх захирлын А-132 дугаартай тушаал, Захирлуудын зөвлөлийн 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 2023/С-11 дугаартай шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Хөгжлийн банкны “Тогтвортой хөгжлийн бодлого”-ыг хавсралтаар баталсугай.
2. Тус бодлогыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Экспорт, импорт, худалдааны санхүүжилтийн газар (Б. Амгалан)-г даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Ж.БАТАА

Монгол Улсын Хөгжлийн банкны Гүйцэтгэх захирлын
2023 оны .11. дүгээр сарын 21-ны өдрийн
А-141 дугаар тушаалын хавсралт



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Бодлогын зорилго

- 1.1. Монгол Улсын Хөгжлийн банк (цаашид “Банк” гэх)-ны “Тогтвортой хөгжлийн бодлого” (цаашид “Бодлого” гэх)-ын зорилго нь банкны үндсэн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгэм болон зохистой засаглалын (цаашид “БОНЗ” гэх) чиглэлээр баримтлах үндсэн зарчмуудыг тодорхойлох, удирдах үйл ажиллагааг зохицуулахад оршино.
- 1.2. Энэхүү бодлогын хүрээнд банк нь Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилттой уялдаж, мөн урт хугацаанд тогтвортой хөгжихийн тулд байгаль орчин, нийгэмд ээлтэй, сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагааг дэмжих, зохистой засаглалын тогтолцоог бүрдүүлэх, тогтвортой хөгжилд чиглэсэн зээл, санхүүжилтийн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэн ажиллахыг зорьж, банкны дунд, урт хугацааны стратеги төлөвлөгөө болон бизнес төлөвлөгөөнд тогтвортой санхүүжилтийн үйл ажиллагааг тусгаж биелэлтийг хангана.
- 1.3. Банк нь санхүүжилтийн үйл ажиллагааг ашиглах замаар уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенцын Парисын хэлэлцээрийн дагуу хүлэмжийн хийн ялгаралтын хэмжээг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтийн улмаас учрах сөрөг нөлөө, эрсдэлийг багасгах, түүнд дасан зохицох үндэсний зорилтод хувь нэмрээ оруулахыг эрмэлзэнэ.

2 дугаар зүйл. Бодлогын хамрах хүрээ

- 2.1. Бодлого нь банкны тогтвортой хөгжлийн чиглэлээр баримтлах зарчим, удирдлага, хяналт болон тайлагналын үйл ажиллагааг тодорхойлсон үндсэн баримт бичиг байна.
- 2.2. Банк нь үндсэн үйл ажиллагаандаа тогтвортой хөгжил болон тогтвортой санхүүжилтийн чиглэлээр нэгдэн орсон гишүүн байгууллагуудын зарчим, стандартуудтай уялдуулна.
- 2.3. Энэхүү бодлого нь БОНЗ-ын дараах бичиг баримтуудтай уялдсан байна. Үүнд:
 - 2.3.1. Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого;
 - 2.3.2. Засгийн Газрын 2019 оны 407 дугаар тогтоолоор батлагдсан “Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилт”;
 - 2.3.3. Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс 2022 онд баталсан “Тогтвортой санхүүгийн үндэсний замын зураг - Санхүүгийн салбарын 2030 он хүртэл хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”;
 - 2.3.4. “Монгол Улсын Тогтвортой санхүүгийн холбоо”-ны Тогтвортой санхүүжилтийн 8 зарчим.

ХОЁР. ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮНДСЭН ЗАРЧМУУД

3 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах чиглэлээр баримтлах зарчим

- 3.1. Монгол Улсын байгаль орчин, нийгэм, эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийг даган мөрдөж, олон улсын банк санхүүгийн байгууллагын байгаль орчин нийгмийн талаарх сайн туршлагыг үйл ажиллагаанд нэвтрүүлнэ.

- 3.2. Банкны үйл ажиллагааны аливаа хэмнэлттэй хэрэглээг бий болгох зорилгоор банкны дотоод хурал, уулзалтуудыг онлайнаар хийх, холбогдох материалыг цаасаар хэвлэж тараахгүй, цахим системийг ашиглах, цахилгаан хэрэгслүүдийг ашиглагдаагүй үед тогтмол унтраадаг байх гэсэн хэмнэлтийн зарчмуудыг баримтална.
- 3.3. Банкны холбогдох газар, нэгжүүд үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөндөө байгаль орчин, нийгмийн хариуцлагын хүрээнд хүрээлэн буй орчинд ээлтэй үйл ажиллагааг нэвтрүүлэх зорилтуудыг тусгах.
- 3.4. Хог хаягдлын менежментийг нэвтрүүлэх: урьдчилан сэргийлэх, арилгах, дахин ашиглах, ангилан ялгах, дахин боловсруулах.
- 3.5. Банкны худалдан авах үйл ажиллагаанд байгальд ээлтэй, ус, эрчим хүчний хэмнэлттэй болон дахин боловсруулагдсан материалаар хийгдсэн эсхүл дахин боловсруулах боломжтой материалаар хийгдсэн бараа материал худалдан авах зарчим баримтална.

4 дугаар зүйл. Нийгмийн хариуцлагыг хүрээнд баримтлах зарчим

- 4.1. Банк нь Нийгмийн тогтвортой хөгжлийн зорилттой уялдуулан соёлын өвийг хадгалж, хамгаалах болон эвдрэн сүйдэхээс сэргийлнэ.
- 4.2. Ажилтны ур чадварыг шударгаар үнэлж урамшуулан, чадварлаг хүний нөөцийг тогтвортой ажиллах ажлын байр бий болгохыг зорино.
- 4.3. Ажлын байрны шаардлагын дагуу хөдөлмөр эрхлэх орчныг бүрдүүлж, ажилд авах, цалин олгох, шийдвэр гаргах, сургалт, урамшуулал олгох ажлаас гарах, тэтгэвэрт гарах зэрэг болон бусад холбогдох үйл ажиллагаанд ижил тэгш боломжоор хангана.
- 4.4. Банкны гүйцэтгэх удирдлагын түвшинд жендерийн тэнцвэртэй байдлыг бий болгохыг дэмжинэ.
- 4.5. Банк нь хүний эрхийг хүндэтгэж, хөдөлмөрийн стандартыг мөрдөж, иргэдийн эрүүл мэндийг хамгаалж, тэдгээрийн аюулгүй байдлыг ханган ажиллахад хувь нэмрээ оруулна.
- 4.6. Жендер эрх тэгш байдал, аливаа хүчирхийлэл болон бэлгийн дарамт, түүний эсрэг хариу арга хэмжээ авах тухай асуудал банкны “Ёс зүйн дүрэм”-д тусгагдсан байна.
- 4.7. Албадан хөдөлмөр эрхлэлт, ажил мэргэжлийн ялгаварлан гадуурхлын эсрэг хатуу байр суурьтай байна.
- 4.8. Банк ажилтандаа ээлтэй, ажиллах таатай орчин, нөхцөлөөр хангах, хүний эрх, жендерийн эрх тэгш байдал болон хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангана.

5 дүгээр зүйл. Зохистой засаглалын чиглэлээр баримтлах зарчим

- 5.1. Компанийн богино, дунд, урт хугацааны төлөвлөгөөнд тогтвортой хөгжлийн зорилтуудыг тусган, хэрэгжилтийг хангаж, БОНЗ-ын эрсдэлийг удирдах замаар үзүүлэлтүүдийг тасралтгүй сайжруулна.
- 5.2. Компанийн үйл ажиллагаанд нөлөөлөх дотоод, гадаад сонирхогч талуудын санал гомдлыг хүлээн авах, хэлэлцэх, шийдвэрлэх, хариу өгөх нээлттэй механизмыг сайжруулна.
- 5.3. Тогтвортой хөгжилд чиглэсэн төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх зорилгоор тогтвортой, ногоон эх үүсвэр татах чиглэлээр зорьж ажиллаж, санхүүгийн хүртээмжийг дэмжинэ.
- 5.4. Банкны санхүүжилтийн чиглэлээр ногоон, тогтвортой санхүүжилтийн бүтээгдэхүүн нэвтрүүлэх тал дээр зорино.
- 5.5. Банк нь тогтвортой санхүүжилтийн үйл ажиллагааны хүрээнд банкны ногоон зээлийн багцын хэмжээг нэмэгдүүлэх чиглэлээр төлөвлөгөө боловсруулж, зорилт тавина.
- 5.6. Банк нь банкны ажилтнуудаас бүрдсэн тогтвортой хөгжлийн үйл ажиллагааг хариуцан ажиллах Тогтвортой хөгжлийн багтай байх бөгөөд тус багт банкны холбогдох газар, нэгж бүрээс төлөөлөгчид багтсан байна.

- 5.7. Банк хуулийг дээдлэн бие даасан засаглалын бүтцийг бий болгох замаар ил тод, нийтэд хүртээмжтэй байдлыг бүрдүүлнэ.
- 5.8. Банк өөрийн шууд болон шууд бусаар харилцаж буй гинжин холбоо бүхий этгээдийн албадан хөдөлмөр эрхлэлт, байгаль орчинд ээлгүй үйл ажиллагаа эрхэлдэг этгээдтэй хамтран ажиллахгүй байхыг эрмэлзэнэ.
- 5.9. Банк санхүүжилт олгосон байгууллага түүнтэй хамтран ажилладаг этгээдээс албадан хөдөлмөр эрхлэлт, байгаль орчинд үзүүлж буй нөлөөтэй холбоотой мэдээлэл гаргуулж авах, аудит хийлгэх тогтолцоог бүрдүүлнэ.

ГУРАВ. ХЯНАЛТ, ТАЙЛАГНАЛ

6 дугаар зүйл. Тайлагнал

- 6.1. Банк нь байгаль орчин, нийгэм, засаглалтай холбоотой аливаа тайланг эх үүсвэр татах, энэ чиглэлийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор олон улсын тайлагналын дагуу хийж гүйцэтгэж болох ба дотоод болон гадаадын аудитын байгууллагаар үнэлүүлж, дүгнэлт гаргуулж болно.
- 6.2. Банк нь жилийн үйл ажиллагааны тайландаа банкны тогтвортой хөгжлийн үйл ажиллагааны тухай нэмэлтээр оруулах эсхүл тусдаа банкны тогтвортой хөгжлийн жилийн тайлан гаргаж болно.
- 6.3. Банкны Тогтвортой хөгжлийн баг нь банкны ногоон зээлийн тайлан, тогтвортой хөгжлийн жилийн тайлан болон бусад холбогдох тайланг боловсруулах ажлыг зохион байгуулна.
- 6.4. Банк нь албан ёсны сайтдаа тогтвортой хөгжлийн булантай болж энэ чиглэлээр гүйцэтгэж буй үйл ажиллагаагаа нийтэд нээлттэй мэдээлнэ.
- 6.5. Банкны үйл ажиллагаанаас үүсэх эрчим хүч, ус, хог хаягдал, хүлэмжийн хий зэрэг үндсэн үзүүлэлтүүдийг банкны холбогдох газар, нэгж жил бүр хэмжиж, банкны бүх ажилтанд тайлагнаж тасралтгүй сайжруулан, үр ашиггүй зарцуулалтыг бууруулна.
- 6.6. Банкнаас санхүүжүүлсэн ногоон/тогтвортой төсөл, хөтөлбөрүүдийн мэдээллийг албан ёсны цахим хуудсаараа дамжуулан нийтэд нээлттэй байршуулна.

7 дугаар зүйл. Хяналт

- 7.1. Байгаль орчин, нийгэм, засаглалын нөлөөллөөс банкны үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх дотоод хяналтын тогтолцоог хэрэгжүүлэх.
- 7.2. Банкны ажилтан бүр Монгол Улсын хууль тогтоомж, Монголбанк болон Банкны эрх зүйн баримт бичиг, түүнд нийцүүлэн гаргасан тушаал, шийдвэрийн дагуу ажил үүргээ гүйцэтгэж үнэнч шударгаар ажиллана. Мөн хамт олны үнэт зүйл, эрхэм зорилт, ёс зүйн үндсэн зарчим, хэм хэмжээг хатуу баримтална.
- 7.3. Банкны тогтвортой хөгжлийн үйл ажиллагаа хариуцсан багийг гүйцэтгэх захирлын тушаалаар байгуулна.

ДӨРӨВ. БУСАД

8 дугаар зүйл. Сургалт, чадавх бэхжүүлэх үйл ажиллагаа

- 8.1. Банк нь тогтвортой санхүүжилтийн үйл ажиллагаа хариуцсан мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэж, чадавхжуулах чиглэлээр зорино.
- 8.2. Дотоод үйл ажиллагаа хариуцсан газар, нэгж нь БОНЗ-ын эрсдэлийн үнэлгээний үйл явцтай холбоотой БОНЗ-ын эрсдэл болон тогтвортой санхүүжилт, жендерийн эрх тэгш байдлын тухай сэдэвтэй сургалт, семинарыг дотоод ажилтнуудад тогтмол зохион байгуулна.

8.3. Банканд шинээр ажилд орж буй ажилтнуудад зориулсан холбогдох сургалтууд БОНЗ-ын эрсдэлийн удирдлага, тогтвортой хөгжил болон тогтвортой санхүүжилттэй холбоотой модулиудыг агуулсан байна.

9 дүгээр зүйл. Бусад

- 9.1. Бодлогын хэрэгжилттэй холбоотой шаардлагатай үйл ажиллагааны зардлын төсвийг төсвийн жилд багтаан батлуулна.
- 9.2. Банк нь зээл, санхүүжилтийн хүсэлтийг судлахдаа байгаль орчин, нийгэм, засаглалын эрсдэлийн үнэлгээг шинжилгээний нэг хэсэг болгон хийнэ.
- 9.3. Банкны Тогтвортой хөгжлийн багийн бүрэлдэхүүн ажлын чиг үүргийг гүйцэтгэх захирлын тушаалаар батална.

--oOo--

Бодлогын хавсралт

1. Монгол Улсын Тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн 8 зарчим

Монгол Улсын тогтвортой хөгжлийн асуудлуудад анхаарлаа хандуулж, банкнуудад Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн бодлогын идэвхтэй оролцогч байхад нь туслах зорилгоор Монгол Улсын Тогтвортой санхүүжилтийн зарчмуудыг боловсруулсан бөгөөд тус зарчмууд нь байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулж, багасгах, бий болохоос зайлсхийхийг эрмэлзэх, түүнчлэн улс орны ногоон эдийн засгийн өсөлт, хөгжлийн зорилгод нийцсэн төсөл, бүтээгдэхүүн, үйлчилгээг санхүүжүүлэхийг дэмжих замаар Монгол Улсын эдийн засгийн олон талт хөгжилд хувь нэмэр оруулах Тогтвортой санхүүжилтийг бий болгох нэг арга зам юм.

Зарчим 1: Байгаль орчноо хамгаалах

Бид хөрс, ус, агаар, биологийн олон янз байдал, байгалийн сэргээгдэх болон сэргээгдэхгүй, шавхагдаж буй нөөцийг хадгалан хамгаалж, тэдгээрт үзүүлэх сөрөг нөлөөллийг бага байхаар тогтвортой ашиглах хандлагыг дэмжин ажиллана.

Зарчим 2: Хүний эрх, нийгмийг хамгаалах

Бид хүний эрхийг хүндэтгэж, хөдөлмөрийн стандартыг мөрдөнө. Иргэдийн эрүүл мэндийг хамгаалж, тэдгээрийн аюулгүй байдлыг ханган ажиллана.

Зарчим 3: Соёлын өвийг хамгаалах

Бид Монгол Улсын түүхэн тодорхой орон зай, цаг үеийг төлөөлөх соёлын онцгой өв болох ёс заншил, хэл, бусад өв, түүнчлэн соёл, түүх, археологи, палеонтологийн түүх соёлын дурсгалыг хадгалж хамгаалан ажиллана.

Зарчим 4: “Ногоон эдийн засаг”-ийн өсөлтийг дэмжих

Бид Монгол Улсын ногоон, цэвэр эдийн засагт хувь нэмэр оруулах төсөл болон бусад үйл ажиллагааг дэмжин ажиллана.

Зарчим 5: Санхүүгийн хүртээмжийг дэмжих

Бид санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэн, санхүүгийн боловсрол олгох, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах арга хэмжээг авах замаар Монгол Улсад санхүүгийн өргөн хүрээтэй тогтолцоог бий болгохыг дэмжин ажиллана.

Зарчим 6: Ёс зүйтэй санхүүжилт, компанийн засаглалыг дэмжих

Бид хориглосон жагсаалтад багтсан үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй, бид ёс суртахуунгүй, гэмт хэргийн шинж чанартай үйлдлийг үл тэвчих бодлого явуулж, ёс зүйтэй байх, компанийн засаглалтай холбоотой сайн туршлагауудыг дэмжих бодлого баримтлан ажиллана.

Зарчим 7: Ил тод байдал, хариуцлагыг дэмжих

Бид ил тод байдал, хариуцлагыг дэмжин, банкны Тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн үүрэг хариуцлагын хүрээнд тайлагнах явдлыг дэмжин ажиллана.

Зарчим 8: Манлайлан үлгэрлэх

Бид харилцагчдадаа тавьж буй шаардлагыг өөрийн бизнесийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж, салбарын хувьд Монгол Улсыг байгаль орчин, нийгэм, эдийн засгийн хувьд эерэг хөгжилд чиглүүлэн ажиллана.

2. Монгол Улсын Алсын хараа 2050 Урт хугацааны хөгжлийн баримт бичиг, (Батлагдсан он: 2020)

Монгол Улс ирэх 30 жилийн хугацаанд 3 үе шаттайгаар Үндэсний нэгдмэл үнэт зүйл, Хүний хөгжил, Амьдралын чанар ба дундаж давхарга, Эдийн засаг, Засаглал, Ногоон хөгжил, Амар тайван аюулгүй нийгэм, Бүс, орон нутгийн хөгжил, Улаанбаатар ба дагуул хот гэсэн 9 зорилгын хүрээнд 47 зорилтыг дэвшүүлж, үе шат бүрд хүрэх үр дүнг тодорхойлон, хэрэгжүүлэхээр тусгасан.

3. Монгол Улсын Үндэсний зорилтот хувь нэмэр 2030 он

2015 он бол онцгой жил болж Парист цугларсан 196 улс гүрний төлөөлөгчид “Парисын хэлэлцээр” хэмээн нэрлэсэн шинэ бичиг баримтыг дэмжсэн юм. Парисын хэлэлцээрийн голлох зорилт нь түүнд нэгдсэн улс орнууд хөгжлийнхөө зам мөр, зүг чигийг гаргахдаа “тогтвортой хөгжил”-ийг эргэлт буцалтгүй баримжаалж дэлхийн агаарын дундаж температурын нэмэгдэх хэмжээ Цельсийн 2 хэмээс давахгүй байх, болж өгвөл бүүр 1.5 хэм дотор барих явдал юм.

Энэ зорилт биелэх боломжийг багцаалахын тулд 2015 оны Талуудын 21 дүгээр Бага хурлын өмнө Парисын хэлэлцээр (ПХ)-т нэгдэх сонирхол бүхий улс орнууд уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад оруулах үндэсний зорилтот хувь нэмэр (ҮЗХН) буюу INDC (Intended National Determined Contribution) гэсэн бичиг баримт боловсруулж Конвенцын Нарийн бичгийн Дарга нарын Газар (НБДНГ)-т хүргүүлсэн билээ. Монгол Улс ҮЗХН бичиг баримтаа бусад улс орны нэгэн адил боловсруулж 2015 оны 10 дугаар сард Конвенцын НБДНГ газарт хүргүүлсэн бөгөөд ПХ-ийн хэлэлцүүлэгт идэвхтэй оролцож түүнийг дэмжин гарын үсэг зурж улмаар 2016 оны 9 дүгээр сард Монгол Улсын Их Хурал уг Хэлэлцээрийг соёрхон баталсан юм. 2016 оны 12 дүгээр сард ПХ хүчин төгөлдөр болж улмаар улс орнуудын өмнө нь боловсруулсан ҮЗХН буюу INDC бичиг баримт нь Үндэсний Тодорхойлсон Хувь Нэмэр (ҮТХН) буюу National Determined Contribution (NDC) болж нэгэн адил албажсан юм.

4. Тогтвортой санхүүгийн үндэсний замын зураг - Санхүүгийн салбарын 2030 он хүртэл хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, (Батлагдсан он: 2022)

Замын зургийн хүрээнд тогтвортой санхүүг хөгжүүлэх суурь нөхцөл, бодлогын таатай орчин бүрдүүлж, төсөв, санхүүг ногоон хөгжилд чиглүүлэн, ногоон санхүүжилтийн хөрөнгийн урсгалыг нэмэгдүүлэх замаар ногоон банк, санхүүгийн байгууллагуудыг хөгжүүлж, тэдгээрийн байгаль орчин, нийгэм, засаглалын болон уур амьсгалын эрсдэлийн удирдлагыг сайжруулж, ил тод, нээлттэй тайлагналыг дэмжих юм.

Үндсэн зургаан бүлэг, 25 дэд арга хэмжээ бүхий Замын зургийг хэрэгжүүлснээр 2030 он гэхэд банкны салбарын ногоон зээлийн багцыг нийт зээлийн багцын 10 хувьд хүргэх, банкнаас бусад санхүүгийн байгууллагын олгосон нийт зээлийн багцын таваас доошгүй хувийг ногоон зээлээр бүрдүүлэх зорилт тавьж байна.

Ингэснээр Монгол Улсын олон улсын өмнө хүлээсэн Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг биелүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн багадаа 15 хувийг банк, санхүүгийн байгууллагуудын эх үүсвэрээс хангах боломж бүрдэж байна.